



УЛААНБААТАР ХИВС
хувьцаат  компани

**“УЛААНБААТАР ХИВС” ХУВЬЦААТ
КОМПАНИЙН 2025 ОНЫ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
МАТЕРИАЛ**

Улаанбаатар хот
2025.04.21

ЭРХЭМ ХҮНДЭТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ЭЭ !

Монгол улсын Компанийн тухай хууль болон компанийн дүрмийн дагуу “Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04-р сарын 21-ний өдрийн 11.00 цагт компанийн хурлын танхимд хийнэ.

Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хурал зохион байгуулах комисс

Комиссын дарга: Утас: 88023515,

e-mail: battsetsegnambar@gmail.com

Гишүүд : Утас:70142556, 99116313

Факс :11-343311,

e-mail : ubcarpet@gmail.com

Web site : www.mongolia-carpet.mn

Facebook page: Улаанбаатар хивс ХК

**“Улаанбаатар хивс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
2025 оны ээлжит хурлын хэлэлцэх асуудал**

- 1. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны үр дүн, 2025 оны үндсэн зорилт, үзүүлэлтийн тухай**
- 2. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт**
- 3. Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны 2025 оны зардлын төсөв батлах тухай**

ХУРЛЫН ДЭГ

1.Хурлын ирцийг бүртгэж, мэдээлэх

Тооллогын комисс
30 минут /10:40-11:10/

2.Хурлын хэлэлцэх асуудал, хурлын дэг тогтоох

Хурлын тэргүүлэгчид
10 минут

3.“Улаанбаатар хивс” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны үр дүн,
2025 оны үндсэн зорилт, үзүүлэлтийн тухай

Илтгэгч ТУЗ-ийн дарга
Ц.Зоригт 20 минут

4.“Улаанбаатар хивс” ХК-ийн санхүүгийн тайлан аудитын
байгууллагаас өгсөн дүгнэлт

Илтгэгч: ТУЗ-ийн дэргэдэх аудитын
хорооны гишүүн/ 10 минут

5. Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны 2025 оны зардлын төсөв
батлах тухай

Илтгэгч:ТУЗ-ийн н.б.д Н.Батцэцэг
10 Минут

7. Хэлэлцсэн асуудлын талаархи санал, шүүмжлэл

Хурлын тэргүүлэгчид
Хүн тус бүрд 5 минут/

8. Хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулж, дүнг танилцуулах
Тооллогын комисс 30 минут

9. Хурлын шийдвэрийн төслийг батлуулж, хурал хаах

Хурлын тэргүүлэгчид 10 минут

Хурлыг 04-р сарын 21-ний өдрийн 11:00 – 14:00 цагт багтаахаар
төлөвлөсөн.



УЛААНБААТАР ХИВС
хувьцаат  компани

“УЛААНБААТАР ХИВС” ХК-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол улсын, машинт аргаар хивс нэхэх анхны үйлдвэр болох “Улаанбаатар хивс” ХК нь 1971 онд БНАГУ-ын /хуучин нэрээр/ техник эдийн засгийн тусламжтайгаар баригдаж, 1992 онд 100 хувь хувьчлагдаж, хувьцаат компани болсон.

Компани нь одоогийн байдлаар 120 гаруй ажилчидтай, хонины ноосыг бэлтгэж, угаасан ноосоор ээрмэл утас бэлтгэн төрөл бүрийн өнгө, дизайнтай Алтанбулаг, Алтан-Өргөө, Саян, Богд, Улаанбаатар, Алтан-Өргөө, Отгонтэнгэр нэртэй цэвэр ноосон хивс үйлдвэрлэж дотоод, гадаадын хэрэглэгчдийн хэрэгцээнд нийлүүлдэг. Үүнээс гадна захиалгат хивс, эсгий гудас, машины суудлын бүрээс, улавч, тааран цүнх, килим /ноосон бүтээлэг/, сүлжмэл бүтээгдэхүүн зэрэг бусад туслах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнүүд үйлдвэрлэн зах зээлд борлуулж байна.

“Хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг, сонирхлыг эрхэмлэн дээдэлж, хивсний үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлж,

хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах, улмаар улс нийгмийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулах нь компанийн эрхэм зорилго юм.”

Компанийн 50 гаруй жил тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж, олон зуун хүнийг ажлын байраар хангаж, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэн, дотоод, гадаадын зах зээлд нийлүүлж, улс орны хөгжилд оруулж ирсэн хувь нэмрийг үнэлж, 2024 оны 10-р сард МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн дээд шагнал “АЛТАНГАДАС” одонгоор шагнасан нь хамт олны цаашдын ажилд урам өгсөн үйл явдал байлаа.

“Улаанбаатар хивс” ХК нь хувьцаа эзэмшигчдийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаас дэвшүүлсэн зорилт, шийдвэрүүдийг хэрэгжүүлж, техник, технологийн шинэчлэл хийх, бүтээгдэхүүний өртөг зардлыг бууруулах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, гадаад дотоодын хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн олон нэр төрлийн, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлээ тэлэх зэрэг үндсэн зорилтуудыг хэрэгжүүлж, компанийн нийт ажилтнууд, хамт олны хүч хөдөлмөрийг зүй зохистой зохион байгуулж ажиллаж ирлээ.

Манай компани нь 2025.03.14-ний бүртгэлийн өдрөөр:

- Үнэт цаасны 52 БДК-ийн 891 хувьцаа эзэмшигчтэй
- Компанийн зах зээлийн үнэлгээ 15.7 тэрбум төгрөг байна.
- Өнгөрсөн 52 долоо хоногийн дундаж үнээр нэгж хувьцааны үнэ 24,600-56,300 төгрөгийн хооронд хэлбэлзлэлтэй байв.

- Нийт хувьцааны 95,4 хувь нь 8 хувьцаа эзэмшигчид төвлөрдөг ба 7 гадаадын иргэд, компаниуд цөөн тооны хувьцааг эзэмшдэг.
- Компани 2023 онд нэгж хувьцаанд 1750 төгрөгийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан нийт хувьцаа эзэмшигчдийн дансанд шууд олгосон бол тайлант 2024 оны үйл ажиллагааны үр дүнгээр нэгж хувьцаанд 2000 төгрөг олгохоор 2025 оны 02-р сарын 17-ны ТУЗ-ийн хурлаар шийдвэрлээд байна.
- Бид компанийн тухай, үнэт цаасны тухай хууль, журмыг мөрдөж, МХБ болон үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагуудтай зохих ёсоор хамтран ажиллаж, холбогдох гэрээ, мэдээ, тайлан, төлбөр тооцоог зохих журмын дагуу хэрэгжүүлж ирсэн.
- 2024 онд компанийн ТУЗ 3 удаа танхимаар хуралдаж, асуудал шийдүүлж ажиллалаа.
- СЗХорооны тогтоолын дагуу “Компанийн засаглалын кодекс”-ыг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох журмуудыг шинэчлэн боловсруулж, компанийн website-д байршуулсан. Компанийн засаглалтын кодексын хэрэгжилтийг, 2024 оны эхний хагас жилд СЗХ-оос хянан баталгаажуулснаар 2024 оны эхний хагас жилд, 108 компаниас 43-рт жагссан байна.

ТУЗ-ийн даргын хувьд, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, техник, технологийн шинэчлэлийн ажилд биечлэн оролцож, гүйцэтгэх удирдлагатай хамтдаа идэвхитэй ажиллаж, цаг үеийн тулгамдсан асуудлуудыг газар дээр нь хэлэлцэн шийдвэрлэж ажилласан болно.

“УЛААНБААТАР ХИВС” ХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

1. Маркетинг-борлуулалтын талаар:

- Тайлант онд 52170 м2 хивс буюу 6,87 тэрбум төгрөгний борлуулалт хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 23,2%-аар өссөн буюу ТУЗ-өөс тогтоож өгсөн үзүүлэлт 110,8 % -ийн биелэлттэй байлаа.
- Хивсний борлуулалтын дундаж үнэ 130,614.0 төг/м2 байлаа
- Нийт борлуулалтын 5,0% нь захиалгат борлуулалт байсны дотор “Чингис” хаан”-ы музей дэх Чингис хааны хөшөөт хүндэтгэлийн танхимын 460,0м2 хивс, төрийн ордны 560,0 м2 хивсийг тус тус үйлдвэрлэж суурилуулсан байна.
- 1 170,1 сая төгрөгийн цэвэр ашигтай байсан нь өнгөрсөн оныхтой харьцуулбал, 2,3 %-аар өссөн байна.
- Улаанбаатар хивс ХК фейсбүүк 66000 гаруй лайктай байгаа ба дагагчдын тоо өмнөх оныхоос 10% нэмэгдэж, 1 500 000 гаруй болсон байна.
- Жилийн турш 45 удаагийн facebook live, 57 удаагийн бичлэг цацсан нь жилдээ 6120 минутын шууд бичлэг болж байна. Бичлэг цацсаны дараахь 2-3 өдрүүдэд нэрийн барааны дэлгүүрүүдийн орлого 25-50% өсч байв.
- Жилдээ амралт, баяр ёслолын өдрүүдийн хямдралтай худалдаа 26 удаа зохион байгуулсан.
- Бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд ойртуулах зорилгоор нийслэлийн БЗДүүрэгт шинээр борлуулалтын цэг нээж ажиллууллаа.

- ОХУ-ын Улан-Удийн “Буриад экспо” үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцов.
- Жилдээ 4100 ширхэг буюу 860, 0 сая ₮-ийн сүлжмэл бүтээгдэхүүн борлуулав.
- “Алтанбулаг” нэрийн барааны дэлгүүрт хивсний агуулах, хувцас солих өрөөг нэмж, тохижуулсан.
- Сүүлийн жилүүдэд, хивсний борлуулалтын зах зээлд өрсөлдөөнд тодорхой өөрчлөлт гарсан нь, БНТурк улсаас хивс, хивсэнцрийн импортын хэмжээ эрс нэмэгдсэн, борлуулалтын төрөлжсөн цэгүүд олноор нээгдэн, маркетингийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн, эдгээр нь хэрэглэгчдийн тодорхой хэсгийг татах болсонтой холбоотой байна.

2. Үйлдвэрлэлийн хүрээнд:

Монгол дахь хивсний үйлдвэрлэлийн 11,63%-ийг “Улаанбаатар хивс” ХК эзэлж байна.

- Тайлант онд компани 52068,0 м2 хивс үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 1679,0 м2-аар илүү байна.
- 260,3 тн ноосыг 641,7 сая төгрөгөөр бэлтгэж, угаалган ашиглалаа.
- Нарийн ээрэх цехэд 115,3 тн ноос боловсруулж, 77,8 тн ээрмэл ээрлээ.
- Аппарат ээрэх цехэд 24/2 номерын ээрмэл 61,7кг; 12/1 номерын ээрмэл 1871,8 кг; 24/1номерын ээрмэл 14,7 кг-ийн тус тус үйлдвэрлэв.
- Будах цехэд 88590 кг утас будаж ороов.
- Хялгас ялгах цехэд 6711 кг хольсон ноосноос 2425 кг хялгасыг ялгасан ноос ялгав. /Гарц 36%/

➤ Нэхэх цех 52371,4 м² хивс нэхэв. Нэр төрлөөр нь үзвэл:

○ Алтанбулаг	33 853,2 м ²
○ Алтан-Өргөө	443,0 м ²
○ Саян	17593,0 м ²
○ Улаанбаатар	12,6 м ²
○ Богд	469,6 м ² тус тус нэхэв.

➤ Оёдол, сүлжмэлийн цехэд машины суудлын иж бүрдэл 146 ширхэг, эсгий гудас 26 ширхэг, хивсэн углааш 200 ширхгийг тус тус үйлдвэрлэж тушаав.

➤ Инженерийн байгууламж:

- Цехүүдийн техникийн чердаканд их цэвэрлэгээ хийсэн.
- Үйлдвэрлэлийн цехүүд болон машин хоорондын гэрэлтүүлгүүдийг сайжруулах, тоолууржуулах ажлыг үргэлжлүүлэн хийв.
- Дэд станц, цахилгааны хамгаалах хэрэгслийн ажиллах зөвшөөрлийг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулан сунгууллаа.
- Тайлант онд цахилгаан эрчим хүчний 95,0 сая ₮-ийн бодит хэмнэлт гаргав.
- Шинэ борлуулалтын цэгийн сантехникийн холболтыг хийв. Нэхэх цехийн тунелийг цэвэрлэв.
- Үйлдвэрийн барилгын дусаал дусдаг хэсгүүдэд хэсэгчилсэн засвар хийв.

➤ Бусад

- Үйлдвэрлэлийн хэмжээнд тоног төхөөрөмжийн ашиглалтын коэффициент 76,0%-96,0 % байсан ба энэ нь мэргэжилтэй ажиллах хүчний хүчний хомсдол, гэнэтийн эвдрэл, түүхий эдийн хүлээлт, оны эхний үйлдвэрийн жигд ажиллагаа алдагдсан зэрэг хүндрэл учирч байсан зэрэгтэй холбоотой. Гэсэн ч ажлын цагийн нягтралыг сайжруулж, илүү цагаар ажиллаж төлөвлөгөөгөө биелүүллээ.
- Өндөр нягттай “Богд” брэндийн шинэ нэр төрлийн хивс үйлдвэрлэх төсөл хэрэгжүүллээ.
- Томруулан ороох автомат машин Autoconer 338 typ RM шинээр суурилууллаа.
- Ажиллагсдын ажлын байрны нөхцөл, өнгө үзэмжийг сайжруулахаар зарим цехийн таазыг давхарлан дулаалсан ба бараа зөөх, хураах тэргэнцэр, тавцангуудыг шинэчиллээ.
- Хяргах 2 машины хутгыг ирлүүллээ.
- Шинэ машин суурилуулах талбайг чөлөөлөх зорилгоор 2 нэхэх машиныг буулгав.

3. Хүний нөөцийн талаар

- Ажиллагсдын тогтвор суурьшлын түвшин 30,1 % байгаа ба дундаж нас 46 байна.
- Нийт ажилтнуудыг эрүүл мэндийн иж бүрэн үзлэг, шинжилгээнд хамруулав. “Гэгээн ар үр” эмнэлэгт 1 ажилчинд 150 000 төгрөг зарцуулав.
- Ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл мэндийг дэмжих зорилгоор спорт заалыг сард

тогтмол 2 удаа түрээслэн, спортоор хичээллэх боломж олгодог болсон.

➤ Нийгмийн хариуцлагын хүрээнд, “Энэрэл” хүүхэд асрамжийн төвийн зааланд хивс суурилуулан өгч, компанийн ажиллагсад нэг өдрийг хүүхдүүдтэй өнгөрөөв.

➤ ХУД-ийн Цагдаагийн хэлтсийн ажилд дэмжлэг үзүүлэх үүднээс жил бүр шаардлагатай ажилтнуудыг хивсэн бүтээгдэхүүнээр шагнадаг болов.

Компанийн ТУЗ, хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталж өгсөн 2024 оны үндсэн үзүүлэлтүүдийн биелэлтийг нэгтгэн үзүүлбэл:

№	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Үйлдвэрлэлт	52000 м2	52068 м2	0,13 % илүү
2	Борлуулалт	6 200 000,0 мян. ₮	6 870 000,0 мян.₮	10,8 % илүү
3	Хөрөнгө оруулалт	600,0 сая ₮	203,2 сая ₮	Томруулан ороох автомат машин авсан. Хөрөнгө оруулалтын зарим төсөл хойшлогдсонтой холбоотойгоор гүйцэтгэл төлөвлөснөөс бага бна.
4	Цэвэр ашиг	900,0 сая ₮	1170,1сая₮	30% илүү
5	Үйлдвэрлэлийн нэгж өртөг	94 000 ₮/м2	95 466 ₮/м2	Түүхий эд, ажиллагсдын цалин хөлс, эрчим хүчний зардал өссөнөөс

2025 оны үйл ажиллагааны үндсэн зорилт

2025 онд үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийн төлөвлөгөөг дараахь байдлаар тогтоож байна.

- Үйлдвэрлэл	53 000 м2
- Борлуулалт	7 100 000,0 мян. төгрөг
- Хөрөнгө оруулалт	1 600 000,0 мян. төгрөг
- Цэвэр ашиг	1 185 000,0 мян. төгрөг
- Үйлдвэрлэлийн нэгж өртөг	104 000.0 төгрөг/м2

2025 онд компани эдгээр үндсэн үзүүлэлтүүдийг ханган биелүүлэхийн тулд дараахь ажлуудыг гүйцэтгэх болно.

- Одоогийн ажиллаж байгаа бүтээмж муутай, элэгдэлд орсон 2 нэхэх машиныг буулган талбай чөлөөлж, өндөр бүтээмжтэй АЛЪФА 360 маркийн нэхэх машин худалдан авч ашиглалтанд оруулна.
- Өнгөрсөн жилд үйлдвэрлэлийн сул зогсолтын 34% нь ажиллах хүчний дутагдлаас шалтгаалсан байсанд дүгнэлт хийж, мэргэжлийн ажилчин бэлтгэхэд тодорхой ажлуудыг зохион байгуулна.
- Борлуулалтын цэгүүдийн тохижилтыг сайжруулна.

Манай компанийн хамт олон 2025 онд үйлдвэрлэл технологийн шинэчлэл, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний нэр төрөл, чанар, сав баглаа боодлыг сайжруулж, гадаад дотоод харилцаа, борлуулалтын сүлжээг нэмэгдүүлэхэд анхаарал тавьж дээрх зорилтуудаа хэрэгжүүлэн ажиллах болно.

Бид монгол хонины цэвэр ноосон утсаар нэхсэн хивс дэлхийн өнцөг булан бүрд хүрч, хивсний илч дулаан, таатай мэдрэмжийг хэрэглэгчдэд бий болгохын төлөө ажиллана.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.



АЯА ТАКС АУДИТ ХХК

Улаанбаатар хот, СБД, I хороо, V
хороолол, 14251, Чингисийн өргөн
чөлөө 19-Б Бизнэс тауэр 11 давхар
Утас: 99994447, 98658500

2025.04.16 № 25/17
Танай _____ ны № _____ -т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Өөрчлөлтгүй дүгнэлт

Бид Улаанбаатар хивс ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмгийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн чухал бодлогууд, бусад тайлбар тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Улаанбаатар хивс ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлангуудад санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг СТОУС-ын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага

Компанийн удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулах хариуцлагыг болон залилан эсвэл алдаанаас шалтгаалан материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг хангахад шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтын үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудиторын хүлээх хариуцлага

Бидний хүлээх хариуцлага нь хийж гүйцэтгэсэн аудитдаа үндэслэн санхүүгийн тайлангуудад дүгнэлт өгөх явдал юм. Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. Эдгээр стандартууд нь санхүүгийн тайлангууд нь материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөөлөж гүйцэтгэх, өс зүйн шаардлагуудыг мөрдөж ажиллахыг шаарддаг.


Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Аудитын горимуудын

сонголт нь санхүүгийн тайлангууд нь аливаа заль мэх, алдаанаас шалтгаалан материаллагаар буруу илэрхийлэгдэх эрсдэлүүдийн үнэлгээг багтаасан аудиторын шийдлээс хамаарна.

Тэдгээр эрсдэлийн үнэлгээг хийхдээ аудитор санхүүгийн тайлангуудыг үнэн зөв бэлтгэн толилуулахтай холбоотой байгууллагын дотоод хяналтын системийг харгалзан үзэх бөгөөд энэ нь байгууллагын дотоод хяналтын үр дүнтэй байгаа эсэх талаар дүгнэлт өгөх зорилгоор биш, харин нөхцөл байдалдаа тохирсон аудитын горимуудыг тодорхойлоход чиглэнэ.

Аудит нь мөн байгууллагын удирдлагын сонгон хэрэглэж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудын бодитой байдал, санхүүгийн тайлангуудын ерөнхий толилуулгыг үнэлэх ажлуудыг багтаана.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан аудитын хязгаарлалттай дүгнэлтийн суурь болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт итгэж байна.



АЯА ТАКС АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

2025 ОНЫ 4 ДУГААР
САРЫН 16-НЫ ӨДӨР

**УЛААНБААТАР ХК-ИЙ 2024 ОНЫ АУДИТЛАГДСАН
САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН**

БАЛАНСЫН ЗҮЙЛ	12/31/2023	12/31/2024	Аудитлагдсан
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,686,356,235	1,693,322,250	1,693,322,250
Дансны авлага	594,674,963	545,044,084	545,044,084
Татвар, НДШ-ийн авлага	102,305	5,831,435	5,831,435
Бусад авлага	25,706,386	54,351,164	54,351,164
Бараа материал	1,953,605,672	2,357,980,671	2,357,980,671
Урьдчилж төлсөн зардал тооцоо	1,289,926,939	1,762,558,775	1,762,558,775
Үндсэн хөрөнгө	10,422,433,026	10,059,298,649	10,059,298,649
Бусад эрэлтийн бус хөрөнгө	1,920,000	1,920,000	1,920,000
НИЙТ ХӨРӨНГӨ	15,974,725,525	16,480,307,028	16,480,307,028
Дансны өглөг	519,757,289	601,555,270	601,555,270
Банкны богино хугацаат зээл	1,877,944,101	1,883,345,660	1,883,345,660
Ногодол ашгийн өглөг	2,119,800	2,119,800	2,119,800
УОО	131,439,664	25,722,400	25,722,400
Үүнээс: төсөөт төлөх	55,345,323	97,548,744	97,548,744
Нийт өр төлбөрийн дүн	2,586,606,177	2,610,291,874	2,610,291,874
Хувьцаат өр төлбөр	40,482,900	40,482,900	40,482,900
Эздийн өмчийн бусад хэсэг	11,834,725,134	11,834,725,134	11,834,725,134
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	1,512,911,314	1,994,807,120	1,994,807,120
Өмчийн нийт дүн	13,388,119,348	13,870,015,154	13,870,015,154
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	15,974,725,525	16,480,307,028	16,480,307,028

**УЛААНБААТАР ХК-ИЙ 2024 ОНЫ АУДИТЛАГДСАН
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

Үзүүлэлт	12/31/2023	12/31/2024	Аудитлагдсан
Борлуулалтын орлого (цэвэр)	5,573,788,401	6,866,337,531	6,866,337,531
Борлуулалтын өртөг	4,088,496,225	4,838,275,894	4,838,275,894
Нийт ашиг (алдагдал)	1,485,292,176	2,028,061,637	2,028,061,637
Түрээсийн орлого	722,583,776	730,943,204	730,943,204
Хүүгийн орлого	120,437,159	26,841,974	26,841,974
Бусад орлого	770,016,408	910,317,297	910,317,297
Борлуулалт, маркетингийн зардал	567,209,136	889,686,746	889,686,746
Ерөнхий ба удирдлагын зардал	407,673,512	476,302,384	476,302,384
Бусад зардал	857,902,008	1,007,899,015	1,007,899,015
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гэрз)	15,666,648	(7,061,807)	-7,061,807
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,281,211,511	1,315,214,160	1,315,214,160
Орлогын татварын зардал	133,982,763	145,109,055	145,109,055
Татварын дараах ашиг (алдагдал)	1,147,228,749	1,170,105,105	1,170,105,105
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,147,228,749	1,170,105,105	1,170,105,105
Орлогын нийт дүн	1,147,228,749	1,170,105,105	1,170,105,105
Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	2,834	2,890	2,890


УЛААНБААТАР ХК-ий 2024 ОНЫ АУДИТЛАГДСАН
ӨМЧИЙН ӨӨРЧӨЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	40,482,900	34,161,659	11,800,563,475	1,001,264,096	12,876,472,130
Залруулсан үлдэгдэл	40,482,900	34,161,659	11,800,563,475	1,001,264,096	12,876,472,130
Зарласан ногдол ашиг	-	-	-	(635,581,530)	(635,581,530)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,147,228,749	1,147,228,749
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	40,482,900	34,161,659	11,800,563,475	1,512,911,314	13,388,119,348
Залруулсан үлдэгдэл	40,482,900	34,161,659	11,800,563,475	1,512,911,314	13,388,119,348
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,170,105,105	1,170,105,105
Зарласан ногдол ашиг	-	-	-	(688,209,300)	(688,209,300)
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	40,482,900	34,161,659	11,800,563,475	1,994,807,120	13,870,015,154

**УЛААНБААТАР ХК-ИЙ 2024 ОНЫ АУДИТЛАГДСАН
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАИЛАН**

Үзүүлэлт	12/31/2024	Аудитлагдсан
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1 <u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	9,454,758,445	9,454,758,445
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	8,697,648,752	8,697,648,752
Бусад мөнгөн орлого	757,109,693	757,109,693
1.2 <u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	8,816,689,599	8,816,689,599
Ажиллагсад төлсөн	2,203,514,577	2,203,514,577
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	494,000,000	494,000,000
Бараа материал худалдан авахад төлсөн	3,126,778,560	3,126,778,560
Ашиглалтын зардалд төлсөн	703,912,803	703,912,803
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	8,160,354	8,160,354
Хүүний төлбөрт төлсөн	-	-
Татварын байгууллагад төлсөн	1,030,489,914	1,030,489,914
Бусад мөнгөн зарлага	1,249,833,391	1,249,833,391
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	638,068,846	638,068,846
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1 <u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	26,841,974	26,841,974
Хүлээн авсан хүүний орлого	26,841,974	26,841,974
2.2 <u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	2,690,997	2,690,997
Хүүгийн татвар	2,690,997	2,690,997
2.3 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	24,150,977	24,150,977
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1 <u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	20,843	20,843
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	20,843	20,843
3.2 <u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	655,274,650	655,274,650
Эзэл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг	653,593,560	653,593,560
Валютын ханшийн тэгшитгэлийн албагдал	1,681,090	1,681,090
3.3 Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(655,253,807)	(655,253,807)
4. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	6,966,015	6,966,015
5. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,686,356,235	1,686,356,235
6. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,693,322,250	1,693,322,250

“Улаанбаатар хивс” ХК-ийн 2024-01-01-нээс 2024-12-31-ний хугацаанд хувьцааны өөрчлөлтийг харуулбал,



“Улаанбаатар хивс” ХК-ийн
хувьцаа эзэмшигчдийн
2025 оны 04-р сарын 21-ний өдрийн
хурлын тэргүүлэгчдийн
02/2025 тоот тогтоолын
Хавсралт №01

**ТУЗ-ийн 2025
оны үйл
ажиллагааны
зардлын төсөв**

№	Зардлын товч утга	Нийт дүн [₮]
1	Цалин: - 64,320 мян ₮ <u>Хурлын ирцийн нэмэгдэл:</u> - 19,200 мян. ₮	₮ 83,520,000.00
2	Бичиг хэрэгслийн зардал	₮ 500,000.00
3	Хэвлэл, телефон холбооны зардал	₮ 2,000,000.00
4	Бусад, сургалт, аттестатчилал	₮ 2,000,000.00
	Дүн	₮ 88,020,000.00

